



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/40

Мандалговь

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх  
ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн л, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 7 дугаар зүйлийн 7.6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор иргэдийн оролцоонд тулгуурлан хөршийн хяналтыг аймгийн төв болон сум орон нутагт хэрэгжүүлсүгэй.

Хоёр. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийг татан оролцуулж, хамтран ажиллаж, нийтийн эзэмшлийн орон сууц, хүүхдийн талбай, машины зогсоол, гэр хорооллын гудамж талбайг камержуулах ажлыг үе шаттай зохион байгуулахыг аймгийн Цагдаагийн газар (О.Амарсанаа), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Үйл ажиллагаа явуулж буй орчиндоо стандартын шаардлага хангасан гэрэлтүүлэг, камер байршуулах ажлыг эрчимтэй зохион байгуулахыг албан байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, удирдлагуудад даалгасугай.

Дөрөв. Энэхүү захирамжийг иргэд, олон нийтэд сурталчилж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Түвшинбаяр)-т, биелэлт, үр дүнг 2019 оны 6, 12 дугаар сарын 5-ны дотор аймгийн Цагдаагийн газарт тайлагнахыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010105